



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ӨЛЗИЙТ ТОСГОНЫ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын тэргүүлэх аудитор :
Ч.Эрдэнэбаатар
Утас:70562112 70562147

Аудитын менежер :
Д.Оюунтуяа
Утас: 70562147

Хаяг:
Хэнтий аймаг дахь Төрийн
Аудитын Газар
Хэнтий аймаг
Хэрлэн сум
Сариг баг
Монгол улс
Цахим хуудас:
www.khentii@audit.gov.mn

“Ай Жэй Эй Эйч Аудит “ ХХК
Захирал: Г.Энхмаа
Утас:99040059 450279
Цахим хаяг:
ljah_audit_2008@yahoo.com

АУДИТЫН ТАЙЛАН

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ХЭА-2018/14/СТА-ХАК-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн төсвийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 12 дугаар сарын 01-ээс 2018 оны 02 дугаар сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөн Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ний аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төв нь 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 20-нд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Ай Жэй Эй Эйч Аудит ХХК нь аудитыг 2017 оны 12 дугаар сарын 10-аас 2018 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Эрүүл мэндийн тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “ХХОАТ-ын тухай”, “Төрийн албаны тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь: “Эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжинд тулгуурлан чанартай, ээлтэй, жигд хүртээмжтэй, эрсдэлгүй үзүүлэхэд оршино.” гэсэн байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д заасны дагуу “Төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн” шууд захирагч байна гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны төсвийг Эрүүл мэндийн яамнаас Хэнтий аймгийн Төрийн сангаар дамжуулан олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 4 дансанд 12 аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын

үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

/ТАБ-СТА-В-2/

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт боломжийн хэмжээнд байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал”-ын дагуу “СТS” программаар тус тус нягтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайланг гаргажээ. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 177568,7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 177406,6 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 162,1 мянган төгрөгөөр хэмнэж, буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 235,0 мянган төгрөгний санхүүжилт авч тээвэр шатахууны зардалд зарцуулжээ.

Шилэн дансны мэдээлэл

www.shilendans.gov.mn вэб сайтад Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төв нь 2017 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлээ 12 сарын байдлаар оруулсан ба 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, санхүүжилтийн гүйлгээнээс өөр гүйлгээ мэдээлэл байхгүй байна.

Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: НДШ-ийн, байгууллага хоорондын тооцооны авлагыг тайланд тусгаагүй байх, эмч сувилагч нарын илүү цагийн тооцоог буруу хийх, бараа материалын дансны нярвын тайлангийн зарлагын дүн санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнтэй зөрөх, эм боох материалын нярвын тайланд урьд оны /2016 оны/ зарлагын баримтыг оруулж зарлагадсан байх, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо УСНББОУС 17-г баримтлаагүй байх зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийн шаардлагыг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 182232,5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, цалин, авлага, өглөг, хоол, тээвэр шатахуун, түлш халаалт зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 88%, мөнгөн хөрөнгийн 95%, нийт зардлын 80% , нийт хөрөнгийн 65%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг байдлыг нийт зардлын 1% буюу 1951,3 мянган төгрөгөөр тогтоов. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна Үүнд:

1. НДШ-ийн тайлангаар 439,1 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна. Гэвч санхүүгийн тайлангаар НДШ-ийн авлагын үлдэгдэлгүй тайлагнасан байна.
Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байгаа" "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах
2. Эмч, сувилагч нарын илүү цагийг тооцохдоо, сарын цагийн фонд, нэг цагийн дундаж хөлсийг буруу тооцоноос 737,2 мянган төгрөгийн илүү, 167,4 мянган төгрөгийн хөлсийг дутуу олгосон зөрчил илрэв.

Шийдвэрлэсэн: 1. Хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг дагаж мөрдөх

2. Илүү цагийн дундаж хөлсийг тодорхойлохдоо тухайн сарын ажлын цагийн фондоор тооцох
3. Нярвын тайлангийн "Хүнсний материал" дансны нэр төрлийн тайлангийн зарлагын дүн өдөр тутмын зарлагын түүврээс 708.5 мянган төгрөгөөр илүү байна. Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн хоолны зардал нэр төрлийн тайлангийн нийт зардлын дүнгээс 216.8 мянган төгрөгөөр илүү байна.
Шийдвэрлэсэн: 1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "Үнэн зөв байх" зарчим
2. Мөн хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг тус тус мөрдөж ажиллах
4. 2017 оны 1-3 сарын аж ахуйн материалын болон хүнсний материалын тайлан, анхан шатны баримтууд олдохгүй байгаа шалтгаанаар ирүүлсэнгүй. Иймд 1-3 сарын хүнсний материалын өдөр тутмын зарлагын түүврийг хийж чадаагүй тул санхүүгийн программаас дүнг авч тулгалтын горим хэрэгжүүлэв.
Шийдвэрлэсэн: 1. НББ-ийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно"
2. Төсвийн тухай хуулийн 5.1.2-д " Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэснийг тус тус мөрдөж ажиллах
5. Нярвын тайлангийн "Эм боох материал" дансны зарлагын дүн, эмийн захиалгын түүврийн дүнгээс 277,3 мянган төгрөгөөр бага байна. Мөн жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн эмийн зардал, нэр төрлийн тайлангийн зарлагын дүнгээс 696,7 мянган төгрөгөөр илүү байна.
Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байгаа" "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах
6. 2017 оны 1-р сард 2016 оны 3, 4, 6.-р сарын эмийн захиалгын хуудсаар 1422.0 мянган төгрөгийн эм зарлагадсан байна.
Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2.--т нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэснийг мөрдөж ажиллах
7. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, УСНББОУС-ын дагуу элэгдлээ тооцоогүй байна.
Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинээр боловсруулан баталж мөрдөх, үндсэн хөрөнгийн элэгдлээ УСНББОУС-17 стандартыг баримтлан тооцох.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад холбогдох ажил гүйлгээ алдааг залруулав. Материаллаг бус 4665,0 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй тул дахин давтахгүй байх зөвлөмж өгөв.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4665,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч эдгээр зөрчлүүдэд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн гэв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралтууд 8 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Г.БЭЛЭГТ

2018.02.22



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.28 № 06/19
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0600442

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР



ХЭРЛЭН СУМЫН ӨЛЗИЙТ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 1 НДШ-ийн тооцооллын талаар.....	1
Асуудал 2	
Цалингийн зардлын талаар.....	2
Асуудал 3	
Хоолны зардлын талаар	3
Асуудал 4	
Эмийн зардлын талаар.....	4
Асуудал 5	
Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооны талаар	5

2018 оны 2 дугаар сар



Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл Мэндийн төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэрлэн сумын Өлзийт тосгоны Эрүүл мэндийн төвийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: НДШ-ийн
тооцооллын талаар**

Тэргүүлэх ач холбогдол № 1

АГ-ын ажиглалт

НДШ-ийн тайлангаар 439.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна. Гэвч санхүүгийн тайлангаар НДШ-ийн авлагын үлдэгдэлгүй тайлагнасан байна..

АГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байгаа" "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байгаа" "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Цаашид холбогдох хуулийг хэрэгжүүлж, тооцоог хянамгай хийж, тайлан тэнцэлд тусгаж ажиллана.

АГ-ын ажиглалт

Эмч, сувилагч нарын илүү цагийг тооцохдоо, сарын цагийн фонд, нэг цагийн дундаж хөлсийг буруу тооцсоноос 737.2 мянган төгрөгийн илүү олгосон, 167,4 мянган төгрөгийн дутуу олгосон зөрчил илэрлээ.

АГ-ын зөвлөмж

- 1.Нэг цагийн дундаж хөлсийг тооцохдоо тухайн сарын ажлын цагийн фондыг харгалзаж тооцох
2. Хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг дагаж мөрдөх

Эрсдлүүд

Үр дүнгийн тайлангийн зардлыг буруу тайлагнах

Төсвийн захирагчийн хариу

Цаашид холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллана

АГ-ын ажиглалт

1.Няrvын тайлангийн "Хүнсний материал" дансны нэр төрлийн тайлангийн зарлагын дүн, өдөр тутмын зарлагын түүврийн дүнгээс 708,5 мянган төгрөгөөр илүү байна. Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн хоолны зардлын дүн, нэр төрлийн тайлангийн зардлын дүнгээс 216,8 мянган төгрөгөөр илүү байна.

2. 2017 оны 1-3 сарын аж ахуйн материалын болон хүнсний материалын тайлан, анхан шатны баримтууд олдохгүй байгаа гэсэн шалтгаанаар ирүүлсэнгүй. Иймд 1-3 сарын хүнсний материалын өдөр тутмын зарлагын түүврийг хийж чадаагүй тул санхүүгийн програмаас дүнг авч тулгалтын горимоо гүйцэтгэв.

Эрсдлүүд

Холбогдох хууль, журам зөрчигдөх, бараа материалыг үр ашиггүй зарцуулах

Үр дүнгийн тайлангийн зардлыг

буруу тайлагнах

АГ-ын зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "Үнэн зөв байх" зарчим,

2. Мөн хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно".

3. Мөн хуулийн 13.7 "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно"

4. Төсвийн тухай хуулийн 5.1.2-д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэснийг тус тус мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Цаашид холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллана

**Асуудал 4: Эмийн зардлын
талаар**

Тэргүүлэх ач холбогдол №4

АГ-ын ажиглалт

1. 1. Няrvын тайлангийн "Эм боох материал" дансны нэр төрлийн тайлангийн зарлагын дүн, эмийн захиалгын түүврийн дүнгээс 277,3 мянган төгрөгөөр бага байна. Мөн жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн эмийн зардал, нэр төрлийн тайлангийн зарлагын дүнгээс 696.7 мянган төгрөгөөр илүү байна.

2. 2017 оны 1-р сард **2016 оны 3, 4, 6.-р** сарын эмийн захиалгын хуудсаар 1422,0 мянган төгрөгийн эм боох материал зарлагадсан байна.

АГ-ын зөвлөмж

1. Няrvын тайлангийн зарлагын дүн анхан шатны баримтаас их байгаа нь " Оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2. Сангийн сайдын 2014 оны 1 сарын 10-ны 5 тоот тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 2-р хавсралтын дагуу зардлыг ангилан бүртгэж байх. Мөн тушаалын 5-р хавсралтын дагуу бараа материалын дансны ангиллыг зөв хийж байх

3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2-т нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэснийг мөрдөж ажиллах

Эрсдлүүд

Холбогдох хууль, журам зөрчигдөх, бараа материалыг үр ашиггүй зарцуулах

Үр дүнгийн тайлангийн зардлыг буруу тайлагнах

Төсвийн захирагчийн хариу

Цаашид холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллана

АГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо хүчингүй болсон Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан байна.

АГ-ын зөвлөмж

НББ-ийн бодлогын баримт бичгээ шинэчилж УСНББОУС 17-гийн дагуу тооцох

Эрсдлүүд

Холбогдох хууль, журам зөрчигдөх, бараа материалыг үр ашиггүй зарцуулах
Үр дүнгийн тайлангийн зардлыг буруу тайлагнах

Төсвийн захирагчийн хариу

Цаашид НББ-ийн бодлогын баримт бичгээ шинэчлэн боловсруулж үндсэн хөрөнгийн элэгдлийг стандартын дагуу тооцож ажиллана.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ


ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Г.БЭЛЭГТ